



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



World Health
Organization

Representative Office
for Mongolia

**“БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ДЭЛХИЙН 7 ХОНОГ”-ИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

WHO Reference 2023/1417946-0

Purchase Order 203305256

УЛААНБААТАР

2023

ТАНИЛЦУУЛГА.

“Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх дэлхийн 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 18-аас 24-ны өдрийн хооронд **“БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ”** уриатайгаар “Нэг эрүүл мэнд” хөдөлгөөн дор нэгдэн тэмдэглэн өнгөрүүллээ.

1. “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн долоо хоног” аян эхэлж байгаатай холбоотой Эрүүл мэндийн сайд, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, агентлагийн даргын мэндчилгээг нийгмийн сүлжээгээр түгээсэн
2. “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн долоо хоног” аяны талаарх хэвлэлийн мэдээ бэлтгэх
3. Олон нийтийн Ийгл телевизээр 7 хоногийн турш 7 өөр мэдээллийг урсдаг зараар явуулсан.
4. Нийслэл болон орон нутгийн бүх шатлалын эмнэлгүүдэд аянд нэгдэх тухай албан бичиг хүргүүлсэн
5. Иргэд, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийг бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх “Go blue – Цэнхэр өнгөөр давалгаалж нэгдэх” фэйсбүүк нүүр зургийн хүрээг сольж нэгдэхийг уриалсан
6. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэхийг уриалсан видео контентыг орчуулан, дуу оруулан нийгмийн сүлжээгээр түгээсэн
7. Иргэдийг бичил биетний тэсвэржилтээс сэргийлэхийг уриалсан ДЭМБ-ээс гаргасан 10 зурагт хуудсыг орчуулах, түгээсэн
8. Зурагт хуудсыг нийгмийн сүлжээгээр болон эрүүл мэндийн байгууллагуудад түгээсэн
9. Go blue видеог 2 удаа Facebook-ээр бууст хийлгэсэн
10. Олон нийтийн сүлжээ болон телевизүүдэд бичил биетний тэсвэржилтийн талаарх болон зохистой хэрэглээний талаарх ярилцлага болон мэдээлэл бэлтгэж хүргэсэн

Энэхүү удирдамжын зорилтод тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах баримт материалыг боловсруулан, бүрдүүлж зохион байгуулан ажиллалаа.

- Ажлын удирдамж-1
- Төлөвлөгөө-1
- Төлөвлөгөөний төсөв-1

Үйл ажиллагаа тус бүрийн тайланг хавсралтаар хавсаргав.

ДУГНЭЛТ

Аяны хүрээнд Эрүүл мэндийн сайд, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, агентлагийн дарга нарын мэндчилгээг 11 дүгээр сарын 18-аас эхлүүлэн байгууллагын цахим хуудсанд байршуулахад хандалтын тоо 2115 хүнд хүрч 216 хүн бусадтай хуваалцсан байна.

Байгууллагын веб болон цахим хуудсанд бичил биетний тэсвэржилтийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх 4 зурагт хуудсыг байршуулахад хандалтын тоо 1520, нийт 2610 хувь хүн болон албан байгууллага бусадтай хуваалцсан байна.

Мөн байгууллагын цахим хуудсаар “Эмэнд тэсвэртэй бичил биетэн”, “Go blue” 2 видеог түгээхэд 231 хүн хуваалцаж, 10852 хүн үзсэн байна.


Facebook нүүр зургын хүрээг нийт 156 хүн хуваалцаж, 1895 хандалт авсан байна.


Байгууллагын цахим хуудсанд бичил биетний тэсвэржилтийн эсрэг Go blue видеог бүүстлэж 28974 хүнд хүрсэн байна.

Бичил биетний тэсвэржилтийн талаар эмнэлгийн мэргэжилтний бичлэгийг монтажлан нийтэлсэн ба хандалтын тоо 19 хүн хуваалцаж, 791 хүнд хүрсэн байна.

Үйл ажиллагаа тус бүрийн тайланг хавсралтаар хавсаргав.

1. Видео студээр хийлгэсэн агентлагийн даргын мэнчилгээ болон видео бичлэг монтаж хийлгэв.






1. Facebook зурган хүрээ (frame)



2. ВИДЕО ШТОРК

“Эмэнд тэсвэртэй бичил биетэн” 1 минут 11 секунд, “Go blue” 22 секундын олон нийтэд зориулсан мэдлэг, мэдээлэл олгох агуулга бүхий видео шторк орчуулан, дуу оруулсан.



3. Нийт 10 зурагт хуудас орчуулсанаас 4 зурагт хуудсыг байгууллагын цахим хаягт байршуулсан



БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ ЯАГААД ТУЛГАМДСАН АСУУДАЛ БОЛООД БАЙНА ВЭ?

Бактери, вирус, мөөгөнцөр болон шимэгчид нь эмэнд тэсвэртэй болсноор тэдгээрээр үүсгэгдсэн өвчнийг илүү аюултай, эмчлэх боломжгүй болгодог.



АНХААРИХ
БИЧИЛ БИЕТНИЙ
ЭСРЭГ ЭМ БЭЛДМЭЛ
ХЭРЭГЛЭЭ

World Health Organization 75 HEALTH FOR ALL

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ НЬ ЖИЖИГ ХЭМЖЭЭНИЙ АСУУДАЛ БИШ, БИД ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯМРАЛТАЙ ТУЛГАРЧ БАЙНА.



АНХААРИХ
ANTIMICROBIALS
WITH CARE

World Health Organization 75 HEALTH FOR ALL

ТА БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ БҮРЭН БОЛОМЖТОЙ.

Хувийн ариун цэврийг сайтар сахиж, дархлаажуулалтад тогтмол хамрагдсанаар эмэнд тэсвэртэй эмгэг торүүлэгч бичил биетний тархалтаас сэргийлж, бичил биетний эсрэг эмийн хэрэглээг бууруулахад чухал ач холбогдолтой.



АНХААРИХ
БИЧИЛ БИЕТНИЙ
ЭСРЭГ ЭМ БЭЛДМЭЛ
ХЭРЭГЛЭЭ

World Health Organization 75 HEALTH FOR ALL

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ НЬ ХҮН БҮРТ ЮУ ГЭЖ ОЙЛГОГДОХ ВЭ?

Энэ нь хүний амийг аврахын тулд хэрэглэдэг эмүүдийн үйл ажиллагааг зогсоож магадгүй гэсэн үг юм.



АНХААРИХ
ANTIMICROBIALS
WITH CARE

World Health Organization 75 HEALTH FOR ALL

БИД АМЬ АВРАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ДАРААХ БАЙДЛААР ХАДГАЛЖ ЧАДНА

1. Вакцин
2. Зөв оношлогоо
3. Антибиотин болон бусад бичил биетны эсрэг эмийн зохистой хэрэглээ



АНХААРИХ
ANTIMICROBIALS
WITH CARE

World Health Organization 75 HEALTH FOR ALL

БИД ҮҮНД ХАМТДАА

Бидний эрүүл мэнд, амьтдын эрүүл мэнд нь бидний дундын хүрээлэн буй орчинд зэрэгцэн оршдог.



АНХААРИХ
ANTIMICROBIALS
WITH CARE

World Health Organization 75 HEALTH FOR ALL

**ХҮН БҮР ГҮЙЦЭТГЭХ
ҮҮРЭГТЭЙ.**

- ЭМЧ
- МАЛЧИД
- ТА
- ТАРИАЛАНЧИД

Бид хамтдаа хүний амниг аварч, бичил биетний тэсвэржилтээс сэргийлж чадна.

**HANDLE
ANTIMICROBIALS
WITH CARE**

World Health Organization 75 HEALTH FOR ALL

**БИЧИЛ БИЕТНҮҮД
ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ
БОЛСНООР
АНТИБИОТИК-
ИЙН ХҮЧ СУЛАРЧ
БАЙНА.**

Антибиотикийг зохисгүй эсвэл хэтрүүлэн хэрэглэснээр бичил биетний тэсвэржилт үүсэн, энэ нь хүн болон амьтны амь насыг аврах эмчилгээг үр дүнгүй болгох эрсдэлтэй.

**ШААРДЛАГАТАЙ
БИЧИЛ БИЕТНИЙ
ЭСРЭГ ЭМ БЭЛДМЭЛ
ХЭРЭГТЭЙ**


World Health Organization 75 HEALTH FOR ALL

4.Ийгл телевизээр 7 хоногийн турш олон нийт, иргэдэд зориулан “биетний тэсвэржилтийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх” аян эхэлсэн тухай үгэн зар цацсан





4. Олон нийтийн сүлжээг ашиглан Facebook-д байгууллагын цахим хаягаар “Go blue” видеог 2 удаа бууст хийсэн.



6.Батлагдсан удирдамж



“БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ДЭЛХИЙН 7 ХОНОГ”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

2023 оны 10 сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСЛЭЛ

Эмэнд тэсвэржсэн нян, вирус, мөөгөнцөр, шимэгч нь амьтан, хүн, ургамлын аймаг түүнчлэн хүмүүс бидний амьдарч буй орчинд түгээмэл тархсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн төвөөс 2013, 2014 онуудад бүсийн улс орнуудад нянгийн эсрэг эмийн тэсвэржилтийг судалж, тулгарч буй бэрхшээлийг тодорхойлсон. Үүнд: улс орнуудад нянгийн эсрэг эмийн тэсвэржилтээс сэргийлэх цогц бодлого дутмаг, антибиотик эмийн хэрэглээ, нянгийн эсрэг эмийн тэсвэржилтийг хянах үндэсний болон бүсийн тогтолцоо сул, эрүүл мэндийн байгууллагуудад нянгийн эсрэг эмийн тэсвэржилтээс сэргийлэх хариу арга хэмжээ авах тогтолцоо хангалтгүй байгаа зэргийг онцолсон.

Иймд Номхон далайн баруун бүсийн хорооны 65-р чуулганаас “Бүсийн хэмжээнд нянгийн тэсвэржилтийн эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж эхэлсэн. Уг төлөвлөгөөний дагуу жил бүрийн 11 дүгээр сард “Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх дэлхийн 7 хоног”-ийн аянг зохион байгуулдаг. Манай улс 9 дахь жилдээ энэ аянд нэгдэж байна.

Энэ жил **“БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ”** уриатайгаар “Нэг эрүүл мэнд” хөдөлгөөн дор хүн, мал, амьтны эрүүл мэнд, ургамал, байгаль орчны салбар нар хамтарч бичил биетний эсрэг эмэнд тэсвэржилт үүсэхээс сэргийлэхэд чиглэж байна.

ЗОРИЛГО

Хүн ам, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарын ажиллагсдын бичил биетний эсрэг эмийн тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тайлан гаргасан

У.Соёл-Эрдэнэ /ЭАБТСГ-ийн мэргэжилтэн/